



М-СИ-ЭС
ГРУППИЙН
КОМПАНИЙН
НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГЫН
ТАЙЛАН

2018



КОМПАНИЙН ТУХАЙ

Товч танилцуулга

Эрхэм зорилго, үнэт зүйлс

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

Эрүүл мэнд

Боловсрол

Байгаль орчин

Бусад төсөл, хөтөлбөрүүд

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Сургалт

Нийгмийн халамж

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД, ТООН МЭДЭЭЛЛҮҮД

2018 онд М-Си-Эс Группийн 25 жилийн ой тохион Үнэт зүйлс, баримтлах зарчимдаа нэмэлт өөрчлөлт оруулан Тогтвортой хөгжлийн зарчмыг нэмсэн онцлох жил байлаа. Энэ хүрээнд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дээдлэн, Нийгмийн хариуцлагын бодлогоо түүний зорилтуудтай уялдуулан хэрэгжүүлэхийг эрхэмлэж байна. Үүнтэй холбоотой ESV [ИЭС ВИ] буюу ажил олгогчийн санаачилга, дэмжлэгтэйгээр ажилчид нь байгууллагынхаа үнэт зүйлсэд нийцсэн, ашгийн төлөө бус үйл ажиллагаанд өөрийгөө хөгжүүлэх болон бусдын сайн сайхны төлөө сайн дураар оролцох оролцоог дэмжин, ажилтанд сайн дурын ажилд оролцох тохиолдолд жилд нэг удаа цалинтай чөлөө олгох журмыг батлан хэрэгжүүлж эхэллээ.

М-Си-Эс Групп 2018 онд Нийгмийн хариуцлагын чиглэлээр 40 гаруй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 4 орчим тэрбум төгрөг зарцуулжээ. Үндэсний өв соёл, үнэт зүйлсийн бэлгэ тэмдэг болсон түүх соёлын дурсгалыг хадгалж, хамгаалах зорилготой “Өв Эрдэнэ” соёлын өвийн тэтгэлэгт хөтөлбөрийг Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран хэрэгжүүлж эхлүүлээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд үндэсний хэмжээний томоохон төслүүдийг шалгаруулан, таван жилийн хугацаанд нийт 2 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилт олгох бөгөөд Чойжин ламын сүм музейн уран барилгын хадгалалт хамгаалалт, Богд хааны ордон музейн уран барилгын байгалийн болон нийгмийн гаралтай хүчин зүйлсийн нөлөөллийн судалгааны ажлуудыг эхлүүлээд байна.

М-Си-Эс групп нь өөрийн болон бусад эх үүсвэрүүдээр хөрөнгө оруулалтууд хийн тогтвортой ажлын байр шинээр бий болгож түүнийгээ хадгалах бодлогыг тууштай баримталж байна. 2018 онд нийт 91 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнээс гадна татвар, хураамж, шимтгэлийн төлбөрөө жил бүр нэмэгдүүлж улсын төсвийн бүрдүүлэлтэд бодитой хувь нэмрээ оруулж хувийн хэвшлийг манлайлсан хэвээр байна. Сүүлийн найман жилд улсын төсөвт нийт 2 их наяд төгрөгийн татвар, шимтгэл төвлөрүүлсэн бөгөөд өнгөрөгч 2018 онд 339 тэрбум төгрөгийн татвар шимтгэлийг төлсөн нь өмнөх жилээс 60 гаруй тэрбумаар өссөн үзүүлэлт юм. Бид аливаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад үндэсний компаниудаа дэмжин тэднээс бүтээгдэхүүн, үйлчилгээг түлхүү худалдаж авахыг эрхэмлэн ажилладаг. Группийн компаниуд 2018 онд нийт 1.6 их наяд төгрөгийн худалдан авалт хийснээс дотоодын 2244 аж ахуйн нэгж, байгууллага, 657 хувь хүнээс 972 тэрбум төгрөгийн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ худалдан авсан байна. Үндэсний компаниуд нь бусдыгаа манлайлан дагуулж, үлгэр жишээ болон үсрэнгүй хөгжилд хүрсэн бусад орны туршлагаар Дэлхийн хөгжлийг Монголдоо цогцлоож, хамтдаа сайн сайхан амьдрахын төлөө бид зорьж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна.

Хүндэтгэсэн,



М-Си-Эс Группийн Дэд Ерөнхийлөгч

Д. Энхтүвшин

КОМПАНИЙН ТУХАЙ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

М-Си-Эс Групп буюу “Mongolian Consulting Services” ХХК нь анх эрчим хүчний зөвлөгөө өгөх чиглэлээр 1993 онд байгуулагдсан бөгөөд өдгөө 9000 орчим ажиллагсадтай, бизнесийн олон салбарт үйл ажиллагаа эрхэлж, татвараар дамжуулан улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулагч, баялаг бүтээгч хорь гаруй компанийг эгнээндээ нэгтгэсэн үндэсний томоохон группийн нэг болжээ.

Бизнесийн чиглэл:

Инженеринг, дэд бүтэц
Уул уурхай
Барилга угсралт, үл хөдлөх хөрөнгө
Мэдээлэл, харилцаа холбоо
Хүнс болон өргөн хэрэглээний бараа,
бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, түгээлт
Нийгэмд чиглэсэн төслүүд

Утас:

11-312625

Хаяг:

М-Си-Эс Холдинг ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, Олимпийн гудамж 19, Шангри-Ла оффис, 24 давхар

Вэбсайт:

www.mcs.mn



www.facebook.com/MCSGroupOfficial



www.twitter.com/GroupMCS



www.instagram.com/mcsgroupofficial



www.linkedin.com/company/13642856/admin/

ЭРХЭМ ЗОРИЛГО: “ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙГ МОНГОЛД”

ҮНЭТ ЗҮЙЛС:



МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХИ

Мэргэжлийн өндөр ур чадвартай, өөрийгөө болон бусдыг байнга хөгжүүлдэг.



БАГИЙН СЭТГЭЛГЭЭ

Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг буй болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажилладаг.



МАНЛАЙЛАЛ

Цаашдын ахиц, хөгжлийн боломжийг олж тодорхойлж, бусдадаа ойлгуулан дэмжлэгийг нь авч, тэднийг урам зоригжуулан, хамтдаа бодит үйл хэрэг болгодог.



ӨӨРИЙМСӨГ ҮЗЭЛ

Ажилдаа болон компанидаа өөриймсөг хандаж, сэтгэл гарган ажилладаг.



САНАЛ САНААЧИЛГА

Хөгжүүлэх, сайжруулах, асуудлыг шийдвэрлэх бүтээлч шийдэл, санал санаачилгыг байнга гаргадаг



ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ

Монгол Улсын хууль журмыг алхам тутамдаа дээдэлдэг, аливаад үнэнч шударга ханддаг.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ

Нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажилладаг.

- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг байна.
- Бид ажилтан бүрт хөгжиж, ахиж дэвших орчныг бүрдүүлж, ижил тэгш бололцоо олгоно. Ажилтны өсөж хөгжих, дэвжиж дээшлэх нь тухайн хүний ур чадвар, гүйцэтгэл, оруулж буй хувь нэмэртэй шууд холбоотой байна.
- Бид сайн ажилчин, ажилтан, менежер төдийгүй сайн манлайлагч байхыг эрмэлзэж, бусдадаа үлгэр дууриал үзүүлнэ.
- Бид шинийг сэдэж, аливааг сайжруулах боломжийг цаг ямагт эрэлхийлнэ. Бид шинэ санаа, бүтээлч хандлагыг хөхиүлэн дэмжинэ.
- Бид хамгийн шилдэг шийдэл бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.
- Өндөр чадавхи, олон ургальч санаа бодол бүхий гишүүдээс бүрдсэн, харилцан итгэлцэл, хүндлэлд суурилсан хамтын зүтгэл нь бидний тогтвортой амжилтын үндэс юм.
- Бид зах зээлийн шударга зарчимд тулгуурлан харилцан биенээ дэмжиж, нөхөж ажилласнаар улам их үр дүн гаргах боломж бололцоогоо нэмэгдүүлнэ.
- Бид ажилдаа эзний сэтгэлээр хандаж, компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хайрлан хамгаална.
- Бид зөв зүйлийг зөв арга замаар хийж, Монгол Улсын хууль тогтоомж, М-Си-Эс Группийн Ёс зүйн дүрмийг өдөр тутам мөрдөж ажиллана.
- Бид ажилтан, түнш, хэрэглэгчтэйгээ харилцахдаа үнэнч шударга зарчмыг баримтална.
- Бид нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэнэ.
- Бид хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажиллана.

Бид алхам тутамдаа М-Си-Эс-ийн үнэт зүйлс, баримтлах зарчмуудыг дээдэлнэ.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

М-Си-Эс Групп нь Компанийн нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд Эрүүл мэнд, Боловсрол, Байгаль орчин гэсэн 3 чиглэлийг нэн тэргүүнд авч үздэг.

ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн салбарын хүрээнд Интермед эмнэлэг нь улаан хоолойн гэмтэлтэй өвчтөнд 34,6 сая төгрөгийн өртөг бүхий эхний шатны мэс заслыг үнэ төлбөргүй хийж, ГССҮТ эмнэлгийн түлэнхийн тасаг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг чадавхжуулах төсөл, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Итгэл Ивээлт эмнэлэг болон ЦССҮТ-д эм хэрэгсэл тус тус хандивласан байна. Мөн ХУД-ын 15-р хорооны ахмадуудын арга хэмжээнд 8,552,000₮, Нийслэлийн Амгалан амаржих газарт 2,800,000₮-ийн хандивийг тус



тус өргөн үйл ажиллагааг нь дэмжин ажиллажээ. Интермед эмнэлгийн тайлант онд хэрэгжүүлсэн томоохон төслүүдийн нэг нь төрөлхийн нурууны эмгэгтэй 16 настай охины эмчилгээ байлаа. Тус төслийн хүрээнд БНСУ-ын Анам эмнэлэгтэй хамтран нийт 120 сая төгрөгийн эмчилгээг хийсэн бөгөөд охины үндсэн эмчилгээнээс гадна БНЭУ-ын Аполло, Фортис, БНСУ-ын Анам эмнэлгүүдтэй хамтарсан үнэ төлбөргүй үзлэг, зөвлөгөө, Дорнод, Өмнөговь аймагт дүрс оношлогоо, мэс заслын чиглэлээр хийсэн үнэгүй үзлэг, зөвлөгөө хийлгэсэн юм.

Энержи Ресурс компани БНСУ-ын Пусан хотын Пусанжин дүүргийн Эрүүл мэндийн газартай хамтран Өмнөговь аймгийн Цогтцэций суманд шүд эрүү нүүр, мэдрэл үе мөч, арьс тоо засал, гоо сайхны мэс засал, нүүр будалт зэрэг чиглэлээр гурван эмч, мэргэжлийн гоо сайханч, хөтөч нарын багийг урьж, анхан шатны



үзлэг хийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Давхардсан тоогоор нийт 163 хүн анхан шатны үзлэгт хамрагдаж, үйлчлүүлсэн. Сум дундын эмнэлэг болон өрхийн эмнэлэгт мэдээлэл хүргэснээр түлэгдэлтийн дараах сорвижилттой, арьсны асуудалтай, мэдрэл, үе мөчний чиглэлээр үзүүлэх шаардлагатай иргэдэд мэдээлэл хүргэн зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээ үзүүлж чадсан байна.




М-Си-Эс Групп, тэр дундаа М-Си-Эс Кока-Кола ХХК 2006 оноос өнөөдрийг хүртэл Монгол Улсад сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх үйлсийг тасралтгүй дэмжин өнгөрсөн хугацаанд нийт 3,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг оруулж, Монголын 3x3 сагсан бөмбөгийн баг Азийн аварга, Дэлхийн аваргын шилдэг найман багийн нэг хэмээх хүндтэй алдрыг хүртэхэд хувь нэмэр оруулсаар байна. 2018 онд тохиосон томоохон үйл явдлуудын нэг нь Хөлбөмбөгийн Дэлхийн Аваргын Цомын аялалыг Монгол Улсад анх удаа зохион байгуулсан явдал байлаа. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлсэн улсын хүртдэг цомыг өөрийн нүдээр харж, дурсгалын зураг татуулах үйл ажиллагаанд нийт 5000 гаруй хүн оролцсон юм.

Мөн Сагсан бөмбөгийн 3x3 төрлийн Монгол Улсын шигшээ “Улаанбаатар Хангарьд” баг Филиппин улсын Манила хотод зохион байгуулагдсан ФИБА 3x3 ДАШТ-д эх орноо төлөөлөн оролцож, шилдэг наймд Ази тивээ төлөөлсөн цор ганц баг болсон амжилт үзүүлсэн билээ. Дэлхийн 3x3 сагсан бөмбөгийн түүхэнд эх орныхоо нэрийг анх удаа гаргаж, Монгол Улсын багийн спортын




түүхэнд цоо шинэ хуудас нээсэн бахархам амжилтыг үзүүлсэн шигшээ багийн хамт олонд баяр хүргэн, М-Си-Эс Групп, М-Си-Эс Кока-Кола ХХК 20 сая төгрөгийн шагнал гардуулсан. Мөн баг тамирчдаа зөвхөн тэмцээний бэлтгэлдээ анхаарлаа хандуулж бүх хүчин чармайлтаа гаргахад дэмжлэг болох үүднээс М-Си-Эс Кока-Кола ХХК 2020 оныг дуустал гэрээ байгуулан тогтмол цалинжуулж эхэлсэн юм.

Сагсан бөмбөгийн спортод оруулах хувь нэмэрээс гадна тус компанийн хамт олон элэгний хавдартай өвчтөнд элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчлүүлэгчдэд тусгай эмчилгээний хоол шаардлагатай байдаг хэрэгцээг харгалзан үзэж Хавдар Судлалын Үндэсний төвд эмнэлгийн гал тогоог



шинэчлэхэд зориулж 10 сая төгрөг хандивлав. Мөн “Цус сэлбэлт судлалын үндэсний төв”-тэй хамтран донорын эгнээг өргөжүүлэх, аюулгүй найдвартай цусны хэрэгцээг хангахад зориулан “Цусаа бэлэглэцгээе” арга хэмжээг 2018 оны 6 дугаар сард зохион байгуулж 20 литр цусны нөөц бүрдүүлэн, 160 хүний алтан амь аврах боломжийг олгосон байна. Үүгээр зогсохгүй тус төвд нэн шаардлагатай цусны эргэлт сайжруулах 500,000 төгрөгийн үнэ бүхий бөмбөлгийг хандивлан хүлээлгэн өгчээ.

Скай Резорт компани жил бүрийн өвлийн улиралд “Мянган хүүхдийн цасны баяр”-ыг санаачлан зохион байгуулдаг бөгөөд 2018 онд Монголын Улаан Загалмайн нийгэмлэгтэй хамтран зорилтот бүлгийн 1000 хүүхдийн цасны баярыг үнэ төлбөргүй зохион байгуулж, утаа ихтэй өвлийн улиралд эрүүл агаарт хүүхэд насны гэгээн дурсамжийг бүтээв. Хөтөлбөрийн нийт зардалд 15 сая төгрөгийн үйлчилгээ багтсан болно. Мөн Монголын уулын цанын холбооны Гүйлтийн цанын шигшээ багийн 20, Паралимпийн багийн 4, Сноубордын 2, Монголын Биатлоны Холбооны 10 тамирчдыг үнэ төлбөргүй бэлтгэл сургуулилт хийх боломжоор хангаж өвлийн улирлын турш зам ашиглах төлбөр 54 сая төгрөгийн төлбөрөөс чөлөөлсөн байна.



Юнител Групп 2018 оны дэлхийн аварга шалгаруулах FIBA 3x3 тэмцээний Монгол дахь шууд дамжуулалтыг ивээн тэтгэн, өөрийн мэдээлэл хүргэлтийн сувгуудаараа дэмжин ажилласан юм. Мөн “Пёнчан-2018” өвлийн XXIII олимпийн Монгол дахь шууд дамжуулалтыг дэмжин ажиллалаа. Ингэснээр Монголын баг тамирчдын өвлийн спортыг дэмжих, цаашлаад тив дэлхийн өвлийн спортын наадмуудад амжилтаа ахиулах үйлсэд хувь нэмрээ оруулсан нийгмийн хариуцлагын ажил болсон юм.



М-Си-Эс Эстэйтс компани тархины саажилттай хүүхдүүдийн төлөө хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг “Ээлтэй Ертөнц” ТББ-г дэмжин тэдний чихмэл тоглоом үйлдвэрлэх үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй болгох, цаашлаад “Тархины саажилтын төв” бүтээн байгуулах үйлсийг нь дэмжин ажиллаж байна. Хүүхдүүдийг асрах,



сувилгаа хийх, ээжүүд гар оёмолын үйлдвэрлэл явуулах зорилгоор Вива Сити хороололд 123 м.кв худалдаа үйлчилгээний талбайг гурав дахь жилдээ үнэ төлбөргүй түрээслүүлж байна. 2018 онд гэрээгээ сунган тус хороололд үйл ажиллагаа эрхлэх хугацааг дахин хоёр жилээр сунгасан билээ.

БОЛОВСРОЛ

М-Си-Эс Интернэйшнл ХХК 25 жилийнхээ ойн хүрээнд ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн лабораторийг 50 гаруй сая төгрөгөөр шинэчлэн засварлаж, хүлээлгэн өгсөн билээ. Эрчим хүчний сургууль нь дэлхийн хөгжингүй орнуудын дээд боловсролын байгууллагууд орчин үеийн хамгийн өндөр үр дүнтэй сургалтын арга хэлбэр хэмээн хүлээн зөвшөөрч буй сургалт болох ахисан түвшний CDIO буюу Con-ceive (Сэтгэ), Design (Зохио), Implement (Хий), Operate (Ажиллуул) арга зүйг нэвтрүүлж байгаа юм. Уг арга зүйг дэлхийн 150 гаруй их, дээд сургуулиуд нэвтрүүлсэн бөгөөд Монгол Улсаас анх удаа ШУТИС хэрэгжүүлж байна. Дэлхийн боловсролын арга зүйг Монголд нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулан, оюутнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, асуудлыг бие даан шийдэх,



мэргэжлээрээ дадал хэвшил олж эзэмших, онолын ойлголтоо бодит байдалд туршин судлах зэрэг давуу талыг суралцагчдад олгох лабораторийг ийнхүү шинэчлэн засварлалаа.

Энержи Ресурс компани нь Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийнхөө хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын оюутан залууст амралтаараа ажил эрхлэх, нэмэлт орлого олох боломж олгох, тэдний хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оноос “Амралтаараа ажиллая” цалинтай



хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд 22 оюутан Энержи Ресурс компанийн Ухаа Худаг уурхайн 11 алба нэгжид мэргэжлийн дагуу дадлагажиж ажилласан байна.

Мөн тус компани нь 2013 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран Цогтцэций суманд “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулаад зогсохгүй Улаанбаатар хотоос мэдлэг, туршлагатай багш, удирдлагыг урьж ажиллуулах, англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалт нэвтрүүлэх зэргээр боловсролын менежментийн цогц хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн билээ. Тэгвэл 2018 онд



МУБИС-ийн Математикийн тэнхимийн эрхлэгч Ж.Сандагдорж багштай гэрээ байгуулан, Мөрөөдөл цогцолбор болон Т.Борын нэрэмжит ЕБС-иудын математикийн хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, багш сурагчдын амжилтыг ахиулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Мөн цаашид “Мөрөөдөл” сургуулийн багш нарт үр дүнгийн урамшуулал олгох, менежментийн мэргэшсэн зөвлөх ажиллуулах зэргээр орон нутгийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахаар зорьж байна.

Харин Скай Резорт компанийн хувьд 2018 онд гольфын спортыг хүүхэд залууст таниулан сурталчлах “Богд академи” байгуулан нийт 50 хүүхэд залуусыг хөнгөлөлттэй үнээр гольфын анхан шатны курс сургалтад хамруулсан. Мөн гольфын зүлэг тариалах арчлах туршлага, техникийн хүчин чадлаа ашиглан Монголд анх удаа таримал ногоон зүлэгтэй стандарт хэмжээтэй хөл бөмбөгийн талбай ашиглалтад оруулсан байна.

Интермед эмнэлэг нь 2018 онд нийт 30 орчим байгууллагын 1000 гаруй хүнд эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр, лекц, тойрон аялал зохион байгуулж, нийт 24 сая төгрөгийн үнэ бүхий 42 мянга орчим гарын авлага, зөвлөмж хэвлэн тараасан байна. Мөн олон нийтэд чиглэсэн 10 удаагийн семинар, мэргэжилтнүүдэд чиглэсэн 8 удаагийн семинар, “Цээжний хөндийн мэс заслын хоёрдугаар чуулган”-ыг тус тус амжилттай зохион байгуулсан.

Юнител Групп Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, орчуулагч Г.Акимын орчуулсан “Шашдирын чуулган” номын 1, 2 дугаар ботийг дахин хэвлүүлж Улсын төв номын сан болон нийслэлийн алслагдсан ЕБС, 21 аймгийн төв номын санд хандивласан.

М-Си-Эс Кока-Кола компанийн хамт олон нь хэрэглэгчдэдээ бүтээгдэхүүнийг хэрхэн үйлдвэрлэдэг шат дамжлагын талаар мэдээлэл өгөх зорилготой “Үйлдвэртэй танилцах хөтөлбөр”-ийг 2008 оноос эхлүүлсэн бөгөөд 2018 онд 250 удаагийн аялалаар 6000 зочин үйлдвэртэй танилцсан байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи арван жилийн хугацаанд нийт 55 мянга гаруй зочид уг хөтөлбөрт хамрагдан үйлдвэртэй



танилцжээ. Мөн тус компанийн хамт олон хүүхэд залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хувь хүний хөгжилд чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн “Happiness center” төвийг 2012 оноос хойш ажиллуулж байна. Тус төвд лекц семинар зохион байгуулах танхим, сонирхсон номоо унших номын булан, авьяас чадвараа хөгжүүлж бэлтгэл сургуулилт, тоглолт хийх тайз, тоног төхөөрөмжөөс гадна үнэ төлбөргүй Wi-Fi орчин, X-BOX тоглоомууд бий. 2018 онд тус төв нь 28 байгууллагатай хамтран 120 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 26 мянга орчим хүнд хүрч үйлчилсэн байна. 2012 оноос хойш тус төвөөр нийтдээ 253 мянга гаруй хүүхэд залуус үйлчлүүлжээ.

БАЙГАЛЬ ОРЧИН

М-Си-Эс Кока-Кола компани Байгаль орчны удирдлагын ISO 14001:2004 тогтолцоог нэвтрүүлэн үйл ажиллагаагаа чанараар баталгаажуулсаар байна. Мөн тус компанийн “Хаягдал Ус Цэвэршүүлэх Байгууламж” нь усны нөөцийн хамгаалалтад оруулж буй үнэтэй



хувь нэмэр юм. Тус байгууламж нь 2018 онд ХУЦБ MNS4943-2015 стандартыг бүрэн хангасан 111,185 тонн ус цэвэршүүлж “Улаанбаатар хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-т 6420 тонн усыг зам талбай, ногоон байгууламж услах зорилгоор өгсөн. Мөн түгээлтийн машинуудын угаалга, компанийн ногоон байгууламжийн усалгаанд 1450 тонн орчмыг ашиглаж байна. Энэ нь Улаанбаатар хотын цэвэр усны нөөцөөс 7870 тонн усыг хэмнэсэн гэсэн үг юм. Үүнээс гадна М-Си-Эс Кока-Кола ХХК нь Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гардаг хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулах үйлдвэрүүдэд өгч хоёрдогч түүхий эд, бараа бүтээгдэхүүн болгож байна. 2018 онд 487.1 тонн нийт хог хаягдлын 241.1 тонныг буюу 49.5%-ийг гэрээт компаниуд болон бусад байгууллагуудад өгч дахин боловсруулсан байна.

Энержи Ресурс компани 2018 оны зун Цогтцэций суманд болсон үерийн дараа шуурхай арга хэмжээ авч, сумын төв болон барилга, байгууламжийн хуримтлагдсан усыг шавхан зайлуулахын зэрэгцээ хамгаалалтын далан, сувгийг сэргээх, шинээр байгуулах ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэжээ. Түүнчлэн усны инженерүүд маань сумын төв, уурхай орчим тогтсон үерийн усыг тусгай аргаар насосоор цуглуулан, шаврыг тунаасны



дараа үйлдвэрийн хэрэгцээнд эргүүлэн ашиглаж эхэлжээ. Зуны турш цуглуулсан 400,000 орчим куб метр усыг зам усалгаа, баяжуулах үйлдвэр зэрэг уурхайн хэрэгцээнд хэдэн сар ашиглах боломжтой юм байна. Мөн Энержи Ресурс компани нь хог хаягдлыг дахин боловсруулахад ач холбогдол өгч Ухаа Худаг уурхайд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ “3R+R” системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дахиврын цехийг дэргэдээ ажиллуулж, блок, хашаа, сандал, хогийн сав зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тайлант онд уг цехэд хаягдал ашиглан гэр ахуй, барилга, тохижилтод ашиглагдах зургаан нэр төрлийн 70 гаруй бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлжээ. Мөн сумын айл өрхүүдийг хог хаягдлыг ангилан ялгадаг болгох зорилгоор “Ногоон бийр” ТББ-ын санаачилгыг дэмжин хаягдлаар хийсэн 50 поошигийг хогийн савны зориулалтаар хандивласан. Уг хогийн савнуудыг Өгөөмөр багийн хэрэгжүүлсэн “Жишиг гудамж” төсөлд хамрагдаж буй айл өрхүүд болон Сийрст багийн Засаг даргад хүлээлгэн өгснөөр хог хаягдлаа ангилан ялгах туршилтыг эхлүүлэхээр болоод байна.


Энержи Ресурс компанийн Ухаа худаг уурхай нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэ ч утгаараа говь нутгийн онгон байгаль, зэрлэг ан амьтдыг хамгаалах чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг. 2018 онд компанийн зүгээс Монголын зэрлэг байгаль, ан амьтдыг олон нийтэд



таниулах, баримтжуулан онгон байгаль, ан амьтдыг сурталчлан таниулах, баримтжуулах зорилготой “Говийн 5 гайхамшиг” ТВ контентийн төслийг эхлүүлсэн бөгөөд төсөлд шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулж нийт 300 гаруй сая төгрөгийн хандив олгосон юм.

Юнисервис Солюшн компани нь Өмнөговь аймгийн Ухаа худаг салбарт жил бүр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан мод, бут сөөгний тариалалт хийдэг ба энэ жил 50 гаруй мод тариалсан байна.

Юнител Групп 2018 онд байгаль орчноо хайрлан хамгаалах чиглэлээр олон нийтийг хамарсан өргөн хүрээний нийт 7 арга хэмжээнд 500 ширхэг эко хогийн савыг үнэ төлбөргүй байршуулан хогоо ил задгай хаяхгүй байхыг олон нийтэд уриалсан байна. Мөн 2018 оны 7 дугаар сард болсон үерийн гамшигт нэрвэгдсэн Баян-Өлгий аймгийн Өлгий сумын иргэдэд



нийт 12 сая төгрөгийн хандив тусламж үзүүлж гамшгийн үеэр тус аймгийн Юнителийн хэрэглэгчдийг сүлжээндээ үнэгүй ярих, шинэ дугаар үнэгүй авах зэрэг гамшигт өртсөн иргэдийн харилцаа холбооны асуудлыг шийдэхэд өөрсдийн нөөц боломжоор дэмжин ажилласан байна. Үүгээр зогсохгүй ой хээрийн түймрийн голомтод ажиллаж буй албан хаагчдад IRIDIUM үйлчилгээ, үүрэн холбооны сүлжээний явуулын станц илгээж, 25 сая төгрөг хандивлажээ. Юнител Групп жил бүр Их цэвэрлэгээний аяныг уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд компанийн ажилчид идэвх санаачилгатай оролцдог юм. Энэ удаагийн аянд Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулдаг Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэт ДЦС, Эрдэнэт ус ТӨХК, Онцгой байдлын газар, Орхон аймгийн Цагдаагийн газар, Номин их дэлгүүр, Эрдэнэт хивс зэрэг байгууллагын ажилчид, мөн эрүүл мэндийн салбарын ажилтнууд хамтран оролцож 300 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр Эрдэнэтийн Баян-Өндөр Хайрханы энгэр бэл газрыг цэвэрлэсэн. Түүнчлэн “Цэвэр хоггүй орчинд амьдарцгаая” уриан дор Сүхбаатар дүүргийн хот тохижилт, Эрүүл мэнд нийгмийн хүрээлэнгийн газартай хамтран байгаль орчноо цэвэрлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж Сэлбэ голын ойр орчмын цэвэрлэлээ. Цагаан хад-Гашуун Сухайтын замын зүүн талын 3 километр замын хогийг цэвэрлэж, нийт 34 уут хог ачсан.



Скай Резорт компани нь Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай, Ойн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн хариуцан хамгаалах үүрэг бүхий 131,8 га газрын байгалийн унаган төрхийг хадгалах, ургамлын бүтцийг хадгалах хамгаалах зорилгоор 159 мянган куб метр эзлэхүүнтэй 5 хиймэл нуурыг барьж гүйцэтгэсэн бөгөөд 2018 оны байдлаар шинэс 120 ширхэг, 4 настай хайлаас 1600 ширхэг, 2 настай хайлаас 1500 ширхэг, Голт бор 40 ширхэг, зулзган гацуур 120 ширхэгийг тус тус тарьсан бөгөөд нийт 31,472,000 төгрөг зарцуулжээ.

Интермед эмнэлэг цаасгүй эмнэлгийн системийг нэвтрүүлээ. Эмч, мэргэжилтнүүд өвчтөний мэдээлэл, өвчний түүхийг (лабораторийн шинжилгээ, дүрс оношлогооны шинжилгээ, хийгдсэн эмчилгээ, хэрэглэсэн эм тариа гэх мэт) програмд оруулж, мөн эмнэлгийн системд холбогдсон дурын компьютерээс мэдээллийг авах боломжтой байгаа



Тотал дистрибьюшин компани нь тээвэр, түгээлтийн үйл ажиллагаандаа нэн тэргүүнд байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх зарчмыг эрхэмлэдэг бөгөөд тус зарчмын хүрээнд Байгаль орчинд ээлтэй ЭКО Евро5 хөдөлгүүртэй 0 км шинэ 17 машинд нийт 7.21 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.



Мөн тус компани нь Өмнөговь аймгийн Ханбогд суманд өвлийн улиралд зэрлэг ан амьтдыг өлдөж, харангадах аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор уст цэгийг байгуулсан байна. Энержи Ресурс компани болон тус сумын “Говийн бага дархан цаазат газар”-ын ажилтнууд, байгаль орчны байцаагчтай хамтран Цагаанхадны ойролцоох засмал замын зүүн талын уулын энгэрт цөөрмийн

нүх гаргаж бэлдэн, усаар дүүргэсэн. Уг газрын ойр орчимд зэрлэг ан амьтад цангаага тайлахуйц усны нөөц огт байдаггүй учраас компанийн ажиллагсад хиймэл уст цэг дээр тогтмол очиж зориудаар ус хийж бэлдсэнээр уг цооногноос хулан, хар сүүлт, зээр, бор гөрөөс гэх мэт амьтад ундаалж, өлдөж харангадахын аюулгүй болжээ.



Үүгээр зогсохгүй тус компанийн хамт олон өөрсдийн байгуулсан уст цэгүүдийн хатуу хог хаягдлыг цэвэрлэх ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн бөгөөд тайлант онд Хээрийн булаг, Жирмийн булаг, Булаг нэртэй газруудын ойр орчмын 1.2 м3 орчим хатуу хог хаягдлыг цэвэрлэж, сумын нэгдсэн хог хаягдлын цэгт тээвэрлэн хүргэсэн. Компанийн зүгээс

Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дахь Наймантын хөндийд малчдын ахуйн болон мал усалгааны хэрэгцээнд зориулсан хоёр худаг шинээр гарган тоноглосон билээ. Эдгээр худгууд нь ховоо татах зэрэг биеийн хүчний ажиллагаа шаардахгүй, цорго нээснээр

Эдгээр худгууд нь ховоо татах зэрэг биеийн хүчний ажиллагаа шаардахгүй, цорго нээснээр ажилладаг хялбар шийдэлтэй тул малчдын өдөр тутмын ажлыг хөнгөвчилдөг давуу талтай. Өнгөрөгч жил зуншлага тааруу байсантай холбогдуулан малчид болон сумдын удирдлагуудын хүсэлтээр дээрхи худгуудыг нээж, ойролцоо нутагладаг малчдад хүлээлгэн өгсөн.



БУСАД

Юнител Групп 2017 онд санаачлан хэрэгжүүлсэн “Зөв гэр бүл” хөтөлбөрийн үргэлжлэл “Зөв гэр бүл-2” кампанит ажил нь нийгэмдээ эерэг байх, зөв хандлагатай байхыг уриалсан бөгөөд тус кампанит ажлын хүрээнд хийсэн нийгмийн реклам нь сошиал сувгаар 1,7 сая хүнд хүрсэн. Олон нийтэд хүргэсэн видео бүр нь нийгмийн буруу хандлага зуршлыг шүүмжилсэн, зөв байхыг уриалсан юм. Мөн сошиал орчинд “Зөв бай” challenge-ийг өрнүүлж 50 мянга гаруй хүнийг хамруулсан. Мөн “Эерэг Монгол” болон “Эгэл Монгол” хөтөлбөрийг санаачлан Монгол орон даяар хэрэгжүүлсэн юм. Хөтөлбөрийн гол зорилго нь нийгмийн бүхий л салбараас ажил үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэж яваа 8 хүнийг сонгон алдаршуулж, олон нийтэд эерэгээр таниулсан юм.



Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хамгийн том үзэсгэлэн болох ICT EXPO 2018 арга хэмжээний үеэр Юнител Групп салбарынхаа 8 Старт-Ап компанийг дэмжин, экспод оролцох зардлыг бүрэн даасан юм.

М-Си-Эс Кока-Кола компанийн хамт олон уламжлал ёсоор Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2018 оны 5 дугаар сарын 29-ны өдөр ҮСАХ-д Хүүхдийн баяр зохион байгуулж, Бадамлянхуа төв, НЗД-ын Хүүхэд Залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор, БЗД-ийн 62-р цэцэрлэгийн нийт 300 хүүхдийг үнэ төлбөргүй тоглуулан нэрийн бэлгээ гардуулан өгч хүүхэд багачуудад инээд хөөр, аз жаргал бэлэглэж,

хүсэл мөрөөдлийг нь хуваалцаж нэгэн өдрийг хамтдаа өнгөрүүлсэн юм. Мөн М-Си-Эс Кока-Кола компани нь 2012 оноос Дархан хотод байрлалтай “Нарны хүүхдүүд”, Эрдэнэт хотод байрлалтай “Энэрэл” асрамжийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаа бөгөөд дээрх асрамжийн төвүүдэд амьдардаг хүүхдүүдэд Олон улсын



Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон Шинэ жилийн баярын өдрүүдээр бэлэг хүргүүлэн баярыг нь хуваалцдаг. Үүний хүрээнд 2018 онд 300 хүүхдэд гарын бэлэг гардуулсан байна.

“Юнисервис Солюшн” компани Монголын хүүхдийн ордоны чулуун шал өнгөлгөө, хивс цэвэрлэгээг хийн, улмаар тогтмол хамтран ажиллаж, үйл ажиллагааг нь дэмжиж байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

М-Си-Эс групп нь бизнесийн зургаан чиглэлд, 20 орчим компанийн 9000 орчим ажилчидтай үйл ажиллагаагаа явуулж, “Дэлхийн хөгжлийг Монголдоо цогцлоох” эрхэм зорилгын дор эх орныхоо хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтанд хувь нэмрээ оруулах нэгэн үзүүрт сэтгэлээр хичээл зүтгэл гарган ажиллаж байна. Бид байгууллагын соёл, ёс зүйн дүрмийнхээ хүрээнд хүнийг нас, хүйс, шашин, шүтлэг, боловсролын түвшингээр ялгаварлан гадуурхдаггүй бөгөөд нийгмийн эмзэг бүлгүүдийг ялгаварлан гадуурхсан аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй байх бодлогыг тууштай баримталж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахад анхаарч ирсэн.

2018 оны байдлаар М-Си-Эс группийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 32 иргэн тогтвортой хөдөлмөр эрхэлж байна. Түүнчлэн М-Си-Эс группт ажиллагсдын насыг 20 хүртэлх, 20-50, 50-иас дээш гэж ангилж болох бөгөөд дундаж нас нь 32 юм.

ХАМГИЙН ОЛОН АЖИЛТАНТАЙ КОМПАНИУД



АЖИЛЧДЫН САЙН САЙХАНД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СУРГАЛТ

М-Си-Эс группийн Сургалт хөгжлийн алба нь 2005 оноос эхлэн дотоодын сургалтуудаа зохион байгуулж ирсэн бөгөөд 2008 оноос М-Си-Эс Академи нэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус академи нь М-Си-Эс группийн үнэт зүйлсийг түгээн хөгжүүлж, дэлхийн жишигт хүрсэн байгууллагын

чадавхийг бүрдүүлэх, компанийн эрхэм зорилгыг дэмжих 30 гаруй сургалтыг зохион байгуулдаг. 2018 онд 128 удаагийн сургалтад 1767 ажилтан хамрагджээ.

Сургалтанд оролцогчдын тоо

11900 ажилтан (Давхардсан тоогоор)



Компани дотроо
5518

Дотоод сургалт
4592

М-Си-Эс Академи
1767

Сургалтад хамрагдсан ажилтнууд сургалтанд үнэлгээ өгдөг бөгөөд 2018 онд дундаж оноо 4.66/5 байна. Түүнчлэн компаниуд ажилчидаа мэргэшүүлэх чадавхжуулаад зогсохгүй сэтгэл зүйн эрүүл мэндэд нь анхаардаг. Тухайлбал, Юнисервис Солюшн компани нь ажилтнууддаа зориулан сэтгэл зүйн төвүүдтэй хамтран цуврал Сэтгэл зүйн сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- Сэтгэлийн өнгө сэтгэл зүйн төвийн Г.Наранбаатар “Эерэг хандлагатай чадварлаг ажилтан байх”
- Хэрэглээний сэтгэл судлалын үндэсний хүрээлэн “Гэр бүлийн харилцаа, Эцэг эх хүүхдийн харилцааны сэтгэл зүйн”
- Афа академи “Амжилтын үндэс харилцаа, хандлага” зэрэг орно.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

М-Си-Эс группийн хэмжээнд “Хөдөлмөрийн тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн дагуу дотоод журмуудаа боловсруулан мөрдөж ажилладаг ба ажиллагсдын нийгмийн хамгааллын талаар “Хөнгөлөлт хангамжийн тухай” журмыг баримталж байна. Нийт ажилчидаа 2-3 жилд нэг удаа эмнэлгийн бүрэн үзлэг шинжилгээнд үнэ төлбөрийг компаниас даан хамруулж хэвшсэн. Ажлын байрны онцлог, нөхцөлөөс хамаарч заавал хийгдэх шаардлагатай үзлэг, оношилгоонд хуулийн заасан хугацаанд хамруулж ирлээ.

Юнисервис Солюшн компани нь нийгмийн хангамжийн ажлын хүрээнд өрх толгойлсон эмэгтэйчүүд, компанидаа тогтвор суурьшилтай олон жил ажиллаж байгаа ажилтнуудад чиглэсэн “Сайн үйлсийн аян” зохион байгуулж хэд хэдэн ажлууд зохион байгуулсан.

Үүнд:

- Үйлчилгээний ажилчин Д. Мөнгөндалайн ар гэрт тохиолдолдсон хүнд байдлыг нь харгалзан үзэж туслалцаа дэмжлэг үзүүлэн буцалтгүй тусламж олгосон.
- Гадна талбайн ажилчин С. Түмэнсайханг эрүүл мэндийн цогц эмчилгээнд хамруулж эмчилгээний зардалыг бүрэн хариуцсан.
- Өрх толгойлсон Үйлчилгээний ажилчин Э.Оюунгэрэлд “Сайн үйлсийн аян”-ны хүрээнд таван ханатай гэр бэлэглэж амьдрал ахуйд туслалцаа дэмжлэг үзүүлсэн.
- Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан Б.Золбаярын гэр нь шатаж ар гэрт хүнд гарз хохирол учирсан үед Сайн үйлсийн аян өрнүүлж таван ханатай гэр, зуух, тавилга, хувцас зэрэг амьдрал ахуйд нэн шаардлагатай зүйлсээр хангаж өгсөн.

- Өрх толгойлсон эмэгтэйчүүд, компанидаа тогтвор суурьшилтай олон жил ажиллаж байгаа ажилтнууддаа компанийн зүгээс Ухаа худаг кэмпэд актлагдсан таван ханатай гэр, зуух бэлэглэж сайн үйлсийн аяныг зохион байгуулсан зэрэг ажлууд багтаж байна.

Энержи Ресурс компани орон сууцны Цэций хороололд 16 ажилтныг, Уурхайчин хороололд 54 ажилтныг гэр бүлийн хамт тус тус суурьшуулсан. Мөн тогтвортой ажиллах гэрээний үүргээ биелүүлсэн 11 ажилтанд орон сууц, 33 ажилтанд хашаа газрын өмчлөлийг үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн.

М-Си-Эс Кока Кола компани нь дараах шинжилгээнүүдэд ажиллагчидаа хамруулж Ард даатгал ХХК-ний Гэнэтийн ослын даатгалд бүх ажиллагчидаа хамруулсан байна. Үүнд:

- Давхардсан тоогоор 900 ажилтанг халдварт өвчний шинжилгээнд
- 126 ажилтанг мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн шинжилгээнд
- 40 ажилтанг урьдчилан сэргийлэх вакцинд
- 535 ажилтанг элэгний ВС вирус шинжилгээнд
- 13 ажилтанг биеийн жингийн индекс, сахар болон өөх тосны хэмжээг тогтоох шинжилгээнд
- 413 ажилтанг Sky эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт тус тус хамруулсан байна.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

М-Си-Эс групп нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн хүрээнд боловсруулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, ур чадварын үнэлгээ хийх журам”, “Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах тухай журам”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ослыг бүртгэх, судлан тогтоох журам”-уудыг тус тус мөрдөн ажиллаж байна. ХАБЭА-н бодлогодоо нийгэм, хүний аюулгүй байдал, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах зарчмыг тууштай баримталж ирсэн. Уг бодлогыг хэрэгжүүлэхийн тулд ХАБЭА-н удирдлагын тогтолцоог өндөр түвшинд хөгжүүлэх, ялангуяа сургалт, хяналт, үнэлгээг улам сайжруулах улмаар осол, гэмтлийн тохиолдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байна.

ХАБЭА-н удирдлагын тогтолцооны аудит, үнэлгээ, зөвлөгөө

М-Си-Эс Холдинг компанийн зүгээс хагас жил тутам харьяа бүх компанийн ХАБЭА-н тогтолцоо, үйл ажиллагаанд үнэлгээ өгөх аудит хийдэг бөгөөд дүгнэлтэнд үндэслэн цаашид сайжруулах ажлын заавар, зөвлөмжийг цаг тухайд нь өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

ХАБЭА-н сургалт

Группийн хэмжээнд нийт ажилтнууддаа эрүүл, аюулгүй ажиллах соёл, эерэг хандлага, зөв зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор ажлын байрны ХАБЭА-н сургалтуудыг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Шинээр ажилд орж байгаа болон өдөр тутам ажлаа гүйцэтгэж буй ажилтнуудад сургалт, зааварчилгаа өгөхөөс гадна удирдах ажилтнуудад ХАБЭА-н ойлголт, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт, лекцийг дотооддоо зохион байгуулж байна.

Энержи Ресурс компани нь нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчдийн ажиллагсад 8,7 сая хүн цаг ажилласан тоон үзүүлэлттэй харьцуулахад хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамжийн үзүүлэлт (ХЧТАД) 0.34, мөн нийт гэмтлийн давтамж 3.56 байлаа. Компанийн хэмжээнд хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд “Ослыг тэглэх алсын хараа” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд ноцтой осол гэмтэл, хүний амь нас эрсэдсэн тохиолдол гараагүй болно.

Юнисервис Солюшн компанийн хувьд тайлант онд нийт 32 112 000 хүн цаг аваар осолгүй амжилттай ажилласан. Ийнхүү ажиллахад нөлөөлсөн чухал хүчин зүйлсүүдийн нэг нь нийт ажилчдаа чадваржуулж, мэдлэг мэдээлэлээр тогтмол хангах явдал бөгөөд 2018 онд дараах сургалтуудыг давхардсан тоогоор нийт 3067 ажилтанд 156 910 хүн цагийг зарцуулсан байна. Үүнд:

- ХАБЭА-н ажлын байрны аюулгүй байдал
- Анхны тусламжийн сургалт
- Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал
- Ажлын хувцас хувийн хамгаалах хэрэгсэл
- Аюул, эрсдэлийн сургалт
- Гал, гамшгийн үеийн сургалт
- MSDS ийн бодисны аюулгүй байдал
- Хог хаягдлын сургалт
- Эрүүл ахуйн сургалт
- Цахилгааны аюулгүй байдал
- Өндрийн аюулгүй байдал зэрэг орно.

Мөн тус компанийн хувьд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг олгохдоо эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 тоот тушаалын заалтыг мөрдөн ажилладаг бөгөөд шаардлага бүхий ажлын байранд ажиллаж буй ажилтнуудад хор саармагжуулах бүтээгдэхүүн олгодог. Хор саармагжуулах бүтээгдэхүүнийг доорхи дүрмийн дагуу олгодог. Үүнд:

- Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн нь шингэн бол ажлын нэг өдөрт 1 хүнд 0.25л-ээс багагүй байх
- Витаминжуулсан ундаа болон сүү сүүн бүтээгдэхүүнийг олгох
- Химийн хорт бодистой харьцаж ажилладаг ажилтанд урьдчилан сэргийлэх хүнсний бүтээгдэхүүнийг олгох
- Хүнсний бүтээгдэхүүнийг заавал ажлын байран дээр нь хэрэглүүлэх зэрэг орно.

М-СИ-ЭС ГРУПП НЭГТГЭСЭН ДҮНГЭЭР

ТОП-3 ТАТВАР ТӨЛӨГЧИД БАГТЛАА

Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ хамтран 2018 оны ТОП 150 ААН-ийг шалгарууллаа. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тэргүүлэх хувь нэмэр оруулж



буй ТОП аж ахуй нэгжүүдийн жагсаалтад М-Си-Эс Группээс Энержи Ресурс, Юнител, М-Си-Эс Кока-Кола, М-Си-Эс Интернэйшнл, Юнивишн, Тотал Дистрибьюшн, М-Си-Эс Проперти болон Юнисервис Солюшн, Анунгоо, Шангрила-Улаанбаатар Хотел компаниуд эрэмбэлэгдлээ. 2018 онд М-Си-Эс Группийн компаниуд нэгтгэсэн дүнгээр улсын төсөвт нийт 339 тэрбум төгрөгийн татвар, шимтгэл төвлөрүүлсэн бөгөөд энэ үзүүлэлтээрээ урьдын адил хувийн хэвшилээ манлайлж Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Тавантолгой компанийн дараа орох амжилтыг үзүүлж, Монгол Улсын ТОП 3 татвар төлөгчид багтсан.

ЭНЕРЖИ РЕСУРС КОМПАНИ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ОЛОН УЛСЫН

ШАЛГАРУУЛАЛТААС ТОП ШАГНАЛ ХҮРТЛЭЭ


Энержи Ресурс компани 2018 онд “Ид шидийн орон-2”, Говийн бүсийн аймгуудын нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, “Говийн таван гайхамшиг” зэрэг төслийг 1,5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн ажиллаж байгаа нь нийгмийн хариуцлагын тэргүүлэх жишээ болсон юм. Энэ ч утгаараа 11 дэх удаагийн Global CSR Summit & Awards буюу Компанийн нийгмийн хариуцлагын олон улсын шалгаруулалтаас ТОП шагналыг хүртээд байна.



“ӨВ ЭРДЭНЭ” ХӨТӨЛБӨРТ 2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОНО

М-Си-Эс Групп 25 жилийн ойгоо тохиолдуулан Монгол үндэсний өв соёл, үнэт зүйлсийн бэлгэ тэмдэг болсон түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах зорилготой “Өв Эрдэнэ” соёлын өвийн тэтгэлэгт хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж эхэллээ. Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэх уг хөтөлбөрт үндэсний хэмжээний томоохон төслүүдийг шалгаруулан, таван жилийн хугацаанд нийт 2 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилт олгох юм. Тэтгэлэгт хөтөлбөрийн эхний төсөл болох Чойжин ламын сүм музейн уран барилгын

хадгалалт хамгаалалтын ажлыг БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газар, Чойжин ламын сүм музей, Монголын Урлагийн Зөвлөл зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. Монголын Урлагийн Зөвлөл Чойжин ламын сүм музейг сэргээн засварлахад бэлтгэх зорилгоор 2008 онд архитектурын хэмжилт ба барилгын гэмтэл, 2017 онд байгалийн болон нийгмийн гаралтай хүчин зүйлсийн нөлөөлөл зэрэг 9 төрлийн судалгааг Австрали улсын иргэн Рожер Перрийн дэмжлэгээр хийсэн билээ. Уг судалгааны тайлан, дүгнэлт, зөвлөмжид үндэслэн Чойжин ламын сүм музейн хамгаалалтын бүсийн газар ашиглалтын төлөвлөлт, орчны тохижилтын ажлыг хийж эхлээд байна.



ХӨЛБӨМБӨГИЙН ДЭЛХИЙН АВАРГЫН ЦОМ МОНГОЛ УЛСАД ХҮРЭЛЦЭН ИРЛЭЭ

М-Си-Эс Кока-Кола компани нь Дэлхийн Хөлбөмбөгийн Холбооны албан ёсны түнш бөгөөд хамтын ажиллагааныхаа хүрээнд 2006 оноос эхлэн Дэлхийн Аваргын Цомыг дэлхийн улс орнуудаар аялуулдаг уламжлалтай болсон. 2018 онд цомын аялал дөрөв дэх удаагаа дэлхийн 50 гаруй орноор тойрон аялж байгаа ба М-Си-Эс Кока-Кола Компанийн зүгээс хөлбөмбөг сонирхогч хүн бүрд зориулан Хөлбөмбөгийн Дэлхийн Аваргын Цомын аяллыг Монгол Улсдаа авчирсан түүхэн үйл явдал тохиосон юм.



ТООН МЭДЭЭЛЛҮҮД

